



МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

Хуульд заасан шаардлага: Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн, эдгээр салбарын ажлын дадлага туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн, дараахь шаардлагыг хангасан хүн байна:

- 1/ Монгол Улсын 30-аас дээш насны иргэн, ял шийтгэлгүй;
- 2/ банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн мэргэжлээр магистрын болон түүнээс дээш зэрэг, цолтой.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:

5.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр банк, санхүү, эдийн засгийн салбарын асуудал хариуцсан төрийн байгууллагад өмнө нь ажиллаж байсан хүнийг томилж болно.

6.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төрийн улс төрийн бусад албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, төрийн захиргааны албан тушаалтан, Монголбанкны удирдах албан тушаалтныг томилж үл болно.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	<p>Эцэг/эхийн нэр: Ундраа Ургийн овог: Баядууд Нэр: Хосжаргал Хүйс: Эр Төрсөн он: 1983 Төрсөн газар: Улаанбаатар хот Иргэний харьяалал: Монгол Одоо оршин суугаа аймаг /нийслэл, сум/ дүүрэг: УБ хот Хан-Уул дүүрэг 11-р хороо <i>/мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/</i></p>
1.2	<p>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал МОНГОЛ БАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН</p>
1.3	<p>Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Үгүй бол Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэхийг тодорхой бичих/</i></p> <p style="text-align: center;">Тийм</p>
1.4	<p>Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. <i>/сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ/</i></p> <p>2020-2021 он <div style="margin-left: 100px;">Дижитал эко систем, Мастерийн зэрэг Манчестр Метрополитан Их Сургууль, Англи улс</div></p> <p>2005-2006 он <div style="margin-left: 100px;">Банкны Зээлийн Бодлого, Мастерийн зэрэг Кемерово Их Сургууль, ОХУлс</div></p> <p>2001-2005 он <div style="margin-left: 100px;">Банк санхүү, Баклаврын зэрэг Кемерово Их Сургууль, ОХУлс</div></p>
1.5	<p>Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг</p> <p style="text-align: center;">Үгүй</p>
1.6	<p>Эрүүл мэнд Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана.</p> <p style="text-align: center;">Үгүй</p>

1.7

Эрхэлсэн ажил

Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Эдийн засаг, банк, санхүүгийн чиглэлээр 12-оос дээш жил ажилласан туршлагатай, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвартай болохыг нотлох баримтыг хавсаргана.

Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.

2022 – 2024 он ВРММongolia ХХК-ийн Гүйцэтгэх захирал

НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран, Засгийн Газрын 419 дүгээр тогтоолоор хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн салбарт процессын дахин инженерчлэл хийх” төслийн зөвлөх. Мөн хөрөнгө оруулалт, дижитал эко систем, даатгалын салбарын төслүүдийн зөвлөх, төслийн удирдагчаар амжилттай ажиллаж байна.

2021 – 2022 он МИГ ХХК-ийн Дэд захирал

Даатгалын салбарын шинэ бизнесийн загварыг боловсруулсан. Энэхүү загвар нь МИГ даатгалд одоогийн нөхцөл байдлаа зөвөөр үнэлж, дараагийг дижитал шилжилт хийх боломжийг олгосон. (<https://mig.mn/> Гүйцэтгэх захирал М.Од Утас: 99084031)

2018 – 2019 он Голомт Банк, ВРР төслийн захирал

Голомт банкны Иргэдийн банкны үйл ажиллагаа болон актив пассивын удирдлагын стратеги, бодлого, програмчлалыг боловсронгуй болгох замаар бизнесийн үр ашигыг нэмэгдүүлэх, инновацид суурилсан өөрчлөлтийг нэвтрүүлэх, бизнесийн дараагийн шат болох "Үйлчлүүлэгч төв"-тэй бизнесийн загварыг нутагшуулсан. (<https://golomtbank.com/> Гүйцэтгэх захирал А.Одонбаатар Утас: 99108349)

2014 – 2018 он Голомт Банк, Сувгийн удирдлагы газрын захирал

Бизнес хариуцсан захирлын хувьд, Голомт банкны салбар нэгжүүд, цахим суваг болон харилцагчийн үйлчилгээ зэрэг чиглэлийг хариуцан ажиллаж байв. Салбарын ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэлд суурилсан цалингийн системийг нэвтрүүлсэн.

2010 – 2014 он Голомт банкны салбарын захирал

Салбарын захирлаар ажиллаж байхдаа борлуулалтын төлөвлөгөөгөө давуулан биелүүлж, эсдэлийн удирдлагын чиглэлээр цогц арга

	<p>хэмжээ хэрэгжүүлэн ажиллаж зээлийн чанар, хүртээмжийг сайжруулсан. Салбарын борлуулалт 2012 онд өмнөх онтой харьцуулахад гурав дахин нэмэгдэж, маркетинг, үйл ажиллагааны зардал буурсан нь гол амжилт байлаа.</p> <p>2007 – 2010 он Голомт банк, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн менежер</p> <p>Зэх зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх болон хэрэглээний зээл, бизнесийн зээлийг хөгжүүлэх үндсэн үүрэгтэй ажил юм. Дата анализ, судалгаанд үндэслэн зах зээлийн багтаамжийг тогтоох, хэрэглэгчийн зан төлөвт тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээ шинээр нэвтрүүлж ажилласан бөгөөд Голомт банкны бренд болж чадсан American Express карт, алтны хуримтлал зэрэг бүтээгдэхүүнийг зэх зээлд нэвтрүүлсэн.</p> <p>2006 – 2007 он Голомт банк, Зээлийн эдийг засагч</p> <p>Зээлийн бүтээгэхүүний борлуулалт болон эдийн засгийн судлагаа хийх нь гол ажлын үүрэг байсан.</p>
<p>1.8</p>	<p>Ашиг сонирхлын зөрчил Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэг эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар хувьцаа, аж ахуйн үйл ажиллагааг ямар хугацаанд эзэмшиж, эрхэлж байгаа, эсхүл эзэмшиж, эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i></p> <p>Тийм ВРММongolia ХХК Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигч Үйл ажиллагааны чиглэл: Төрийн болон бизнесийн процессын дахин инженерчлэл хийх зөвлөх үйлчилгээ</p>
<p>1.9</p>	<p>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i></p> <p>Үгүй</p>
<p>1.10</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Сүүлийн таван жил ямар мэргэжлийн холбоо, байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаал, чиг үүрэг гүйтцэтгэж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i></p> <p>Үгүй</p>

1.11	<p>Мэргэжлийн ёс зүйн талаар Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх. <i>/тийм эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i></p> <p>Үгүй</p>
1.12	<p>Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>Монголын Бизнес Зөвлөлийн бүх гишүүдийн уулзалт “ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ 2019” https://goqo.mn/r/34m5k</p> <p>BusinessMN: Бизнесийн салбарын дижитал шилжилт зөвлөгөөн Голомт банкны BPR төслийн захирал У.Хосжаргал https://www.youtube.com/watch?v=b4E0-zlZeTc</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p><i>/Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана/</i></p>

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>/500-1000 үгэнд багтаана/.</i></p> <p>Миний бие Ундраа овогтой Хосжрагал нь 2006 оноос эхлэн банк санхүүгийн салбарт тасралгүй 15 гаруй жил ажиллаж байна. Ажлын гараагаа зээлийн эдийн засагч, ня-бо зэрэг банкны анхан шатны ажлуудаас эхэлж байсан бол сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд салбарын захирал, олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрийн удирлагч Голомт банкны газрын захирал зэрэг удирдах албан тушаалд ажиллаж Монгол улсын банк санхүүгийн системд дижитал шилжилт,</p>
-----	---

процессын дахин инженерчлэл хийх, төлбөрийн системийг өргөтгөх, банкны зээлийн бодлого болон төлбөр түргэн гүйцэтгэх чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаанд гар бие оролцон ажилласан билээ.

Сүүлийн жилүүдэд зарим банкуудын санхүү, төлбөрийн чадвар муудаж, тэдний хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж байгаагаас үзэхэд Төв банк/Монголбанкны тухай хууль болон Банкны тухай хуулийн хэрэгжилт хангалгүй байгааг харуулж байна. Хэдийгээр Төв банк/Монголбанкны тухай хуулийн зорилт нь банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, банк болон банкны нэгдлийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрт албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог ч хэрэгжилтийн шатанд процессын алдаа дутагдал гарч хяналтын тогтолцоо бүрэн хэрэгжиж чадахгүй байгаагаас улсын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх, банкны системийн найдвартай ажиллагааг алдагдуулах, хадгаламж эзэмшигчид болон харилцагчдын эрх ашгийг хохироох тохиолдол гарсаар байна. Төв банк тухай хуулийн 4 дүгээр зүйлийн хоёр дахь заалт: Монгол банк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ гэж заасан байдаг. Мөн Хяналтын зөвлөл нь Монгол банкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монгол банкнаас санхүүгийн тайлангаа Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монгол банкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих эрх бүхий субектын хувьд улс орны эдийн засгийн өсөлтийг хангах чадвар бүхий зах зээлийн зарчимд үндэслэсэн бүтэцтэй, тогтвортой, найдвартай үйл ажиллагаа бүхий банкны тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үр нөлөөтэй няналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай юм.

Миний бие У.Хосжаргал нь Монгол банкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд Монгол банкны Хяналтын зөвлөлийн ажиллах журмын дагуу нягтлан бодох бүртгэлийн олон улсын зарчимд нийцсэн хөндлөнгийн аудитын байгууллагыг Монгол банкны жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэх, аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавих болон олон нийтэд мэдээлсэн санхүүгийн тайлангийн хүрээмжтэй, хүн төвт, цаг үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байдлыг дээшлүүлэхэд өөрийн туршлага ур чадварын дайчлан ажиллах болно. Мөн дотоод хяналтын талаар гаргасан журам, дотоод хяналтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, олон улсын чиг хандлагын дагуу мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх, дижитал шилжилтийг эрчимжүүлэх, хяналтын процессыг сайжруулах талаар холбогдох арга хэмжээ авахыг Монголбанкны удирдлагад санал болгон идэвх санаачлагатай ажиллах болно.